



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/607

Хэрлэн сум

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоо үндэсний чуулганд оролцогчдод дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоо үндэсний чуулганд” оролцогчдод зориулж 1,350,000 (нэг сая гурван зуун тавин мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

3. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ДАЮУРБУНЬ

Аймгийн Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 28-ний өдрийн
А/607 дугаар захирамжийн хавсралт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил оролцоо
үндэсний чуулганд оролцогчдын зардал

	Овог нэр	Албан тушаал	Хоног	Мөнгөн дүн
1	Банзрагч Ургамалсүвд	Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн	2	450,000
2	Доной Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл	2	450,000
3	Даш Оюунчимэг	Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооны тэргүүн	2	450,000
Нийт				1,350,000